



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1780

Улаанбаатар хот

“Зочид буудал, дэн буудал, амралтын газрын”  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,  
сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурван аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэг иргэний дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.


5. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.

6. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 08 сарын 21  
өдрийн А/80 тоот тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.08.25

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Сод тулга ХХК	Сод	Баянзүрх дүүрэг, 25-р хороо, Дамдинсүрэнгийн гудамж 75/2
2	Сонжин групп ХХК	Сонжин Гранд	Баянзүрх дүүрэг, 13-р хороо, Энхтайваны өргөн чөлөө
3	МЧБС ХХК	Соёл	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж 4

-ооОоо-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 20.15 оны 08. сарын 21  
өдрийн 110 тоот тушаалын хоёрдугаар  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.08.25

Улаанбаатар хот

<i>Д/д</i>	<i>Иргэн, аж ахуйн нэгжийн нэр</i>	<i>Оноосон нэр</i>	<i>Байршил</i>
1	Проджи ХХК	Атлас	Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Морин давааны 17130/289
2	Эм Эм Эм Ди ХХК	Кайзер	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 10/28
3	Улаанбаатар зочид буудал ХХК	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Б.Алтангэрэлийн гудамж 7

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 08 сарын 21  
өдрийн 119 тоот тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ИРГЭНИЙ НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.08.25

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Д.Наранзул	Зүүм	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их сургуулийн гудамж, Ану төв

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 08 сарын 21  
өдрийн 110 тоот тушаалын дөрөвдүгээр  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ИРГЭНИЙ НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2015.08.25

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Л.Тамир	Орж гарч бай л даа хө	Сонгинохойрхан дүүрэг, 28-р хороо, Ногоон Чулуутын 5/10 тоот

-ooOoo-